

Ахмад геологич Лувсаншаравын Шархүүгийн дурсамжаас



Тэртээ холын 1960 оны өвөл МУИС-н монгол хэл, уранзохиолын ангиас дадлагын овутнууд манай сургуульд ирж хичээл зааж байхад тэдгээрийн дотроос Очирбат оюутан бидэнд хандаж: Манай сургуульд энгэрсэн намар геологийн анги шинээр нээгдэж анхны элсэлтээ авсан. Тийм учраас та нараас геологийн ангид орж мэргэжил эзэишээд эх орныхоо хөрс, газар доорх баялагийг нээн илрүүлж улс эх орондоо олон ордыг шинээр нээх үйлсэд хүчин зүтгэж алдар луугаа мандуулцгаа! ЗХУ-ын мэргэжилтэнгүүд Бэрхийн хайлуур жонш, Бүрэнцогт, Түмэнцогт, Их хайрханы гянтболд, гэх мэт олон орд илрүүлж, уурхай байгуулан ашиглаж байхад та нар гадаадын хүмүүсээс илүү ихийг бүтээж, эх оронч сэтгэлгээгээр ажиллах хэрэгтэй гэж ухуулан ойлгуулахад миний хувьд сэтгэл хөдлөн энэ мэргэжилийг эзэмших хүсэлд өөрийн эрхгүй автсан юм. Тэр Очирбат (одоо нас барсан) гэгч оюутан нь зохиолч, яруу найрагч хүн байсан юм. Манай ангийн арваад хүүхэд “геологич” болно гэж ярьж байсан боловч би ангиасаа ганцаараа энэ мэргэжлийг эзэмшсэн юм.

1961 оны хавар Дорноговь Сайншандын сургуулийн 10-р анги төгсөж багшаасаа гуйж байж МУИС-ийн геологийн ангийн хуваарь авч намар нь хүссэн сургууль дээрээ ирж элсэлтийн шалгалт “Алгебра, Хими, Монгол хэл, Орос хэлний шалгалтуудыг амжилттай өгч тэнцээд хүсэл болсон мэргэжлийнхээ ангид орох болсондоо хязгааргүй их баярлаж билээ. Хэд хоногийн дараа биднийг машингд суулгаж Төв аймгийн Жаргалантын Сангийн аж ахуйн ногооны 6-р бригадэд Манж даргын мэдэлд төмс хураах ажилд бригад болгон хуваарилаж ажилуулсан юм. 1961 оны 9 ба 10 сарыг дуустал бүтэн 2 сар ажлахдаа ядарч, сүүлдээ даарч байсан минь санаанаас гардаггүй юм. За ингээд би намтарчилан зүйл бичихийн оронд ажиллаж хөдөлмөрлөж явах хугацаанд өөрт тохиолдсон зарим нэгэн адал явдлаасаа сонирхуулах хүсэл төрлөө.

*Хонь гаргаж сурсан минь*

Сангийн аж ахуйд ажиллах явцад бидэнд дандаа ногоотой гурилтай шөл(амт муутай) өгдөг байсан бөгөөд түүнд нь махгүй, заримдаа 1-2ширхэг(жижиглэн хөшиглөсөн) хар мах хөвж харагддаг байв. Мах чанаж идэх юмсан гэж их боддог байв. Нэг өдөр хажуугийнхаа майханд ортол зүс үзсэн хүүхэд тарган мах идэж байхтай таарч (тэр хүүхэд нь элсэлтийн шалгалтын үед надтай тааралдсан байсан) түүнтэй яриа өдөж мах идэж байхдаа, түүнээс чи яагаад ийм сайхан тарган мах олж иддэг аргаа зааж өг гэж тулгав. Тэр хүүхэд гал тогооны хүмүүстэй танил болсон хүүхэд байв. Надаас тэр хүүхэд хонь гаргаж төхөөрч чадах уу гэж асуув. Тэгэхээр нь чи надад зааж өг гэснээр түүнтэй хамтарч (оройн цагаар) хонь төхөөрч шагналд нь өвчүү чануулж иддэг болсон билээ. Ингэж хонь гаргаж сурч билээ.

*Гэртээ унтаж байгаад үнэг алсан нь*

1966 онд МУИС-ийн геологийн ангийг төгсөөд Их-Хайрханы хайгуулын 2-р ангид геологичоор очсон билээ. Тус ангид монгол геологич-инженер байхгүй олон орос мэргэжилтэн байв. Харин монгол техник-геологич Гүржав, Л.Нина, Ц.Баяр нар

байсан юм. Намайг Майхан худгийн хэсэгт явуулж техник геологич Баяртай хамт нэг гэрт оруулсан. Тухайн жилийн геологийн ажил дуусч зөвхөн суваг малталтын ажил дуусаагүй, олон тооны уулын малтагчид тэнд байсан. Шөнө дунд чимээ гарч Баяр намайг сэрээсэн боловч юу ч болсон шинжгүй нам гүм байв. Бид 2 гайхаж байгаад унтаж билээ. Маргааш шөнө мөн л чимээ гарахад босоод нарийвчлан үзэж шалгасан боловч онц мэдэгдсэн зүйлгүй. Харин ханын толгойд өлгөсөн хонины ууц гуятайгаа байсны нэг гуяны махны тал нь алга болсон байв. Нарийн ажиглавал гэрийн хаалганы баруун хатавч доогуураа онгойсон байв. Бид ярилцсаны эцэст нэгэн зэрлэг амьтан хаяагаар орж ирж мах иддэг болохыг тогтоов. Дараа шөнө нь хаяаны онгорхой нүхэнд калибрь буу сумлан тааруулж байрлуулаад гохонд нь хуруугаа дарахад бэлдэж би өөрөө газраар хэвтлээ. Ихэд хүлээсэн боловч нүх битүүрэхгүй онгорхой хэвээр л байлаа. Нойр хүрч, нүд анилдаад их л хэцүү байсан. Гэтэл өнөө нүх маань аажим битүүрэх үед би бууныхаа гохыг дарлаа. Гадаа түжигнэх чимээ гараад нам гүм болов. Гадаа харанхуй, юу ч үзэгдэхгүй байв. Ингээд маргааш өглөө эртлэн босоод гартал гэрийн урдуур өнгөрдөг замын цаана том биетэй улаан шар үнэг үхсэн байв. Очоод аваад үзсэн чинь маш их бүүрэг (бөөс)-тэй байсан тул сэжиглээд гаднаа модноос зүүгээд орхив. Сум амин газар нь туссан байлаа. Уулын ажилтан Асетхаан “Энэ сайхан үнэгээ надад өгөөч” гээд гуйгаад байхаар нь түүнд өгсөн чинь нөхдүүд намайг загнаад “Чиний ангын олз гарч, аз чинь харьсан” гэж хэлдэг байв. Асетхаан (Одоо Эрдэнэтэд ГОК-д ажиллаж байгаа) маань сүүлд нь сайхан улаан лоовуузан малгай хийлгээд өмссөн явж билээ. Түүнээс хойш үнэхээр миний ангийн аз харьсан шүү! Тарвага ч надад алагдахаа больсон. Тэгээд ч би заавал ан гөрөө хийх ёстой биш гэж өөртөө бодоод ан хийх сонирхолгүй болсон билээ.

*Баруун гарынхаа таван хурууг хөлдөөсөн нь*

1967 оны 12-р сарын 20-оор буюу шинэ жил ихэд дөхсөн үе байв. Жилийн ажлын төлөвлөгөө биелүүлэхээр олон тооны суваг малтдаг байв. Малтагч Ширнэнгийн 500м урттай суваг дээр өдрийн оройн харус бүрий болохоос өмнө дуусаж надад түүнийг хүлээн авч дээжлэлт, зураг бичиглэл хийх үүрэг ноогдов. Төлөвлөгөө тасрах гээд байгаа учир заавал хүлээж авах шаардлагатай. Ингээд дээжлэгч 2 ажилтантайгаа хамтарч дээжилж дуусгаад дараа нь зураг бичиглэл хийж эхэлтэл цасан шуурга шуурч хүйтэрлээ. Би өнөөдөр үүнийг заавал дуусгах ёстой, тэгж байж төлөвлөгөөг биелүүлэхийн зэрэгцээ шуурч хунгарласан цасыг дахин (би өөрөө) цэвэрлэх үүрэг ноогдож ажил улам хүндрэх байлаа. Малтагч Ширнэн маань хотруу явсан учир надад туслах боломжгүй болсон. Тэгээд даарч бээрч харанхуй болсон хойно баруун гарынхаа 5 хурууг хөлдөөж байж ажлаа дуусгасандаа. Дараа нь мөстэй усанд дүрж байж хуруугаа гэсгээж билээ. Бэрхшээлээс бүү шантар гэхдээ гөр хөлөө хөлдөөж болохгүй гэж захимаар байна.

*Өлсөх цангахаас аврагдсан нь*

Би халуун нар шарсан говийн нутгаар 1975-1980 онуудад 1:50000 масштабтай геологийн зураглал, эрэл, эрэл-үнэлгээний ажлаар маршрут хийж явахдаа өлсөх, цангах, ядрах, наранд цохиулах зэрэг Түмэн бэрхшээлийг туулж явлаа. Өглөө 8 цагаас оройн 17 цаг, заримдаа 21 цаг хүртэл 15-аас доошгүй урт км маршрут хийж ажиллаж байлаа. Өглөө юм идэж чаддаггүй учраас саванд хар цай, жаахан боорцог аваад ажилд явдаг боловч тэр нь бүтэн өдрийн туршид юу ч болохгүй дуусна. Зарим өдөр огт хүнс, ундаагүй явах үе ч гарна. Тийм үед маш их өлсөж, цангаж ядарч явдаг. Нэг удаа маршрутын замд хөдөөний малчин айл тааралдаж өлсөж цангахаас аврагдаж

билээ. Тэр айлын тавьж өгсөн идээнээс хатсан ааруул (хурууд) хэдэн ширхэгийг авч, дараагийн өдрийн маршрутын явцад түүнийгээ амандаа хүлхсээр яваад байсан чинь ам цангах, өлсөх явдал ер болоогүй. Иймд хойч үедээ захихад: Маршрутанд хатсан ааруул авч явж амандаа хүлхэж яваарай гэж захимаар байна. Маршрутанд би цаашдаа ямагт хатсан ааруул авч явдаг болж хэвшсэн билээ. Энэ мэтээр дурьдаад байвал олон тооны адал явдал, бэрхшээлүүд олон удаа тохиолдож байсан бөгөөд ихэнхийг нь мартжээ. Сонин болгож эдгээрийг дурьдав.

Геологитой амьдралаа холбосон 49 жил, геологийн мэргэжилтэй болсоны 44 жилд асар их зүйл бүтээж чадаагүй хэдий ч явцын дунд тэмдэглэж байсан олон тайлан бусад материалуудаас түүвэрлэн үзэхэд суваг 65750м<sup>3</sup>, шурф 51320т/м, газрын доорх далд нэвтрэлт 7650м, өрөмдсөн керн 125460т/м, эрлийн маршрут 850км, олон зуун мянган дээж, сорьц, чулуун материалаар анхдагч материал бүрдүүлж, тэдгээрийн бичиглэл зураг, схемийг боловсруулан, шинжилгээний үр дүнд тулгуурлан 20 гаруй тайланд оролцож 10-аад тайланг биечлэн удирдан зохион бичсэн байдаг. Энэ хугацаанд шинээр нээсэн том орд 5, илрэл 40 гаруй, эрдэсжсэн цэг 100 гаруйг илрүүлсэн билээ. Шинээр нээсэн ордоос тоймчилбол: Төв аймгийн Их-Хайрханы гянтболдын ордыг хаагдах үед нь үргэлжлүүлэн нээж 1973 он хүртэл тус уурхайг ажиллуулсан, Дорноговь Мандах сумын Цагаанцавын газрын доорх их хэмжээний нөөцтэй цэнгэг усыг 1975 онд илрүүлж, дараа нь Ч.Гомбосүрэн, Д.А.Жевачин нар урьдчилсан хайгуул хийсэн, Өмнөт Монголын зэсийн бүсэд, Бунхант, Улаантолгой, Зээгт, Шүтээний өмнөт хэсэг, Дөчин хурал-II зэрэг зэсийн жижиг орд илрэл зэргийг нээсэн юм.

Дорноговь Мандах сумын Цагаансуваргын зэс-молибденийн ордод 1980-1984 онд нарийвчилсан хайгуулыг удирдан хийлгэж нөөцийг нь үйлдвэрийн зэргээр тооцон бодож, улмаар стратегийн ач холбогдол бүхий орд болгосоны зэрэгцээ 2005-2008 онуудад давтан хайгуул хийж зэс-молибденийн урьд нь бодсон нөөцийг өсгөж нэмэгдүүлэхийн зэрэгцээ алтных нь нөөцийг шинээр бодсон.

Өмнөговь Цогтцэций сумын Хармагтайн алт-зэсийн илрэлд 1979-1980 онд эрэл-үнэлгээ хийж орд болгоод улмаар 2009-2010 онд нарийвчилсан хайгуул хийлцэж алт, мөнгө, зэсийнх нь нөөцийг бодолцов.

Би өөрийн дурлаж сонирхсон энэхүү мэргэжилээр асар их ажил хийж чадаагүйдээ харамсавч бага ч болов ажил бүтээж улс эх орондоо өчүүхэн ч гэсэн нэмэр өгсөндөө бахархадаг.

Ирээдүйн залуу геологчддоо хандаж хэлэхэд: хөдөлмөрлөх эрч хүчтэй залуу нас их богино байдаг юм байна. Иймд насны залууд хугацаа хожиж, амжиж их зүйл бүтээгээрэй, цаг ямагт ном уншиж мэдлэгээ дээшлүүлж байгаарай гэж хэлмээр байна. Геологич хүн 1:200000 ба 1:50000 масштабтай геологийн зураглалд 3-5 жил ажиллаж чулуулгийг маш сайн таньж мэддэг болох, улмаар чулуулаг нь маш ихээр хувирч өөрчлөгдсөнийг мөн таньж сурах, түүндээ үндэслэн ашигт малтмалын орд байж болохыг шинж тэмдэг хувирлаар нь мэддэг болох хэрэгтэй. Үүнд ажлын туршлага маш их нөлөөтэй. Миний хувьд 50 гаруй шавь байдаг. Тэдгээрээс одоо хээрийн геологийн судалгааны ажилд оролцож яваа нилээд бий. Тэд нартаа энэ үгээ хэлж захидаг даа.

Эх орныхоо эрдэс баялагийг нээж, улс орондоо ихийг бүтээх үйлсэд өндөр амжилт гаргахыг нийт геологчиддоо хүсэн ерөөе!

Эрхэм хүндэт та нарыгаа хүндэтгэсэн, өндөр настан,  
ахмад геологич Лувсаншаравын Шархүү